



VIII/2022

Тархаасан: 2022 оны 9 дүгээр сарын 15



Объектын түймэр 2022 оны эхний 8 сарын байдлаар 2088 удаа бүртгэгдлээ

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны эхний 8 сарын байдлаар 2850 болж, өмнөх оны мөн үеэс 251 (9.7%) -ээр өссөн байна. Объектын түймэр 2022 оны эхний 8 сарын байдлаар 2088 удаа бүртгэгдэж, өмнөх оноос 404 (24.0%) -өөр, биологийн гаралтай аюулт үзэгдэл 146 болж, өмнөх оны мөн үеэс 113 (4.4 дахин их) -аар тус тус өссөн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 8 сарын байдлаар нийт 197 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 9 (4.1%) -өөр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2022 I-VIII	2022 I-VIII
					2021 I-VIII
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	3 628	2 974	2 599	2 850	109.7
Газар хөдлөлтийн тоо	26	37	267	47	17.6
Объектын түймрийн тоо	3 053	2 226	1 684	2 088	124.0
Амь насаа алдсан хүний тоо	162	194	206	197	95.6
Учирсан хохирол, тэрбум төгрөг	31.3	108.2	17.4	13.9	79.9
Зарцуулсан зардал, сая төгрөг	1 060.7	255.7	1 985.5	6 592.1	3.3 ¹

¹ - Дахин их

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 8 сарын байдлаар 13.9 тэрбум төгрөгийн хохирол учирч, 6.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Аюулт үзэгдэл:

Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг:

Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.



Эх үүсвэр:

Онцгой байдлын ерөнхий газар;

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 10 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563

